



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 151

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Багш нарын амралтыг буруу тооцсон, өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажилтанд нэг удаагийн тэтгэмж олгосон, үр дүнгийн урамшууллыг төсөв захирагчийн тушаал шийдвэртэй байхад олгоогүй, 2020 онд данснаас хассан хөрөнгийг 2021 онд дахин актлуулахаар санал хүргүүлж, шийдвэр гаргуулсан, Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хугацаа хоцроож оруулсан, шатахууны тооцоо бодоогүй, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, томилолтын зардлыг илтгэх хуудасгүй олгосон зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, и баримтгүй гүйлгээ хийсэн, тогтмол зардлын гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн зэрэг материаллаг 33.7 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

07922345

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,626,833.78	90,643,172.61
33	АВЛАГА	187,671.78	679,062.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	187,671.78	679,062.05
35	БАРАА МАТЕРИАЛ	120,439,162.00	89,964,110.56
35100	Түүхий эд материал	5,436,987.00	6,133,967.00
35110	Тусгай зориулалттай материал	5,436,987.00	5,436,987.00
35130	Эм боох материал	-	696,980.00
35400	Хангамжийн материал	115,002,175.00	83,830,143.56
35410	Бичиг хэргийн материал	152,025.00	564,500.00
35420	Аж ахуйн материал	393,500.00	3,891,817.76
35440	Түлш, шатах тослох материал	36,018,000.00	12,942,000.00
35460	Хүнсний материал	1,036,640.00	2,344,175.80
35470	Бусад хангамжийн материал	77,402,010.00	64,087,650.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,182,033,681.79	2,101,276,560.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,182,033,681.79	2,101,276,560.62
39200	Биет хөрөнгө	2,156,119,681.79	2,075,422,560.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,120,627,424.51	2,120,627,424.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(137,143,076.62)	(190,515,183.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,884,000.00	34,884,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,550,666.71)	(11,550,666.75)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	149,077,204.80	134,139,119.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,899,295.02)	(78,830,093.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,661,331.10	119,598,501.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,286,631.63)	(80,720,932.70)
39217	Ном	27,749,391.36	27,790,391.36
39300	Биет бус хөрөнгө	25,914,000.00	25,854,000.00
39301	Програм хангамж	1,397,500.00	1,397,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,187,500.00)	(1,247,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,704,000.00	25,704,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,302,660,515.57	2,191,919,733.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,000.00	-
41300	Өглөг	10,000.00	-
41360	Бусад өглөг	10,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	10,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,302,650,515.57	2,191,919,733.23
51	Засгийн газрын хувь оролцоо	2,302,650,515.57	2,191,919,733.23
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	316,434,125.90	316,434,125.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,552,057,676.23	1,441,326,893.89
51210	Өмнөх үеийн үр дүн	1,570,203,341.37	1,552,057,676.23
51220	Тайлант үеийн үр дүн	(18,145,665.14)	(110,730,782.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	434,158,713.44	434,158,713.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,302,660,515.57	2,191,919,733.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,049,423,720.50	954,963,060.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,703,616.50	14,804,249.76
120	Нийтлэг татварын бус орлого	44,703,616.50	14,804,249.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,703,616.50	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,703,616.50	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	9,446,352.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	5,357,897.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,004,720,104.00	940,158,811.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	898,101,200.00	901,980,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	898,101,200.00	901,980,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,900,204.00	5,708,711.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,980,304.00	4,555,111.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,919,900.00	1,153,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,718,700.00	32,469,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,718,700.00	32,469,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,067,569,385.64	1,065,249,373.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,067,569,385.64	1,065,249,373.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	976,936,308.64	1,036,067,717.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,639,890.89	729,515,506.26
210101	Үндсэн цалин	622,622,819.89	628,112,971.26
210104	Урамшуулал	59,374,024.00	55,135,947.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,643,047.00	46,266,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,654,266.00	102,890,175.78
210201	Тэтгэврийн даатгал	69,540,450.00	72,581,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	840,000.00	7,278,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,956,147.00	5,821,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,482,300.00	1,455,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,835,369.00	15,753,075.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,211,484.00	52,256,047.52
210301	Гэрэл, цахилгаан	3,789,154.00	4,732,847.52
210302	Түлш, халаалт	37,386,330.00	46,656,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,036,000.00	867,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,640,922.61	30,223,355.00
210401	Бичиг хэрэг	524,875.00	3,075,675.00
210402	Тээвэр, шатахуун	5,066,731.61	4,577,620.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,018,850.00	6,639,700.00
210408	Бараа материал акталсны зардал	3,655,466.00	15,810,360.00
2105	Нормативт зардал	14,208,515.00	25,446,548.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490,500.00	1,098,800.00
210502	Хоол, хүнс	13,462,015.00	24,029,848.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	256,000.00	317,900.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	849,900.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	418,400.00	-
210604	Урсгал засвар	431,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	1,486,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	1,486,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,335,900.00	2,378,581.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,539,900.00	2,378,581.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,353,430.14	91,871,503.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553,200.00	191,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,800,230.14	91,680,003.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,633,077.00	29,181,656.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,714,317.00	11,955,525.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,206,165.00	6,855,266.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,980,304.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,527,848.00	5,100,259.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,655,346.00	165,952.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,649,946.00	165,952.48
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,400.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,263,414.00	17,060,178.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,263,414.00	17,060,178.69
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(18,145,665.14)	(110,286,312.67)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	444,469.67
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	444,469.67
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(18,145,665.14)	(110,730,782.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,005,787,743.00	940,158,811.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,005,787,743.00	940,158,811.00
1310	Улсын төсвөөс	898,168,839.00	901,980,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	898,168,839.00	901,980,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,900,204.00	5,708,711.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	34,980,304.00	4,516,811.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	1,919,900.00	1,191,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,718,700.00	32,469,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	70,718,700.00	32,469,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	999,007,743.00	938,237,811.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	999,007,743.00	938,237,811.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,596,971.00	903,346,320.83
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	724,951,612.00	730,012,272.31
210101	Үндсэн цалин	620,930,371.00	628,609,737.31
210104	Урамшуулал	59,378,194.00	55,135,947.00
210105	Гэрээт ажлын цалин	44,643,047.00	46,266,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,527,655.00	102,884,800.00
210201	Тэтгэврийн даатгал	71,402,000.00	72,581,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	840,000.00	7,278,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,967,986.00	5,821,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,482,300.00	1,455,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,835,369.00	15,747,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,068,754.00	29,180,047.52
210301	Гэрэл, цахилгаан	3,789,154.00	4,732,847.52
210302	Түлш, халаалт	57,243,600.00	23,580,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,036,000.00	867,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,449,300.00	7,953,620.00
210401	Бичиг хэрэг	540,000.00	1,174,050.00
210402	Тээвэр, шатахуун	5,066,950.00	4,577,620.00
210404	Ном, хэвлэл	136,500.00	436,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	375,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,330,850.00	1,645,950.00
2105	Нормативт зардал	15,306,750.00	23,187,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	472,500.00	1,635,000.00
210502	Хоол, хүнс	14,514,250.00	19,552,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	320,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	558,400.00	3,683,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	558,400.00	560,000.00
210604	Урсгал засвар	-	3,123,700.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	1,486,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	1,486,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,335,900.00	2,378,581.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил	3,539,900.00	2,378,581.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,356,600.00	2,579,700.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,356,600.00	2,579,700.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,410,772.00	34,891,490.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,649,946.00	165,952.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,649,946.00	165,952.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,240,824.00	17,060,178.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,240,824.00	17,060,178.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,520,002.00	17,665,359.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,011,850.00	12,565,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай	33,980,304.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,527,848.00	5,100,259.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	6,780,000.00	1,921,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,780,000.00	1,921,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,780,000.00	1,921,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	6,780,000.00	1,921,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,780,000.00	1,921,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(6,780,000.00)	(1,921,000.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,571,108,626.51	2,321,701,465.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(905,285.14)	(905,285.14)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,570,203,341.37	2,320,796,180.71
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,145,665.14)	(18,145,665.14)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,552,057,676.23	2,302,650,515.57
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,552,057,676.23	2,302,650,515.57
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,552,057,676.23	2,302,650,515.57
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(110,730,782.34)	(110,730,782.34)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	316,434,125.90	434,158,713.44	1,441,326,893.89	2,191,919,733.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	934,450,100.00	917,262,268.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	934,450,100.00	917,262,268.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	916,784,700.00	899,596,909.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,871,100.00	730,012,272.31
210101	Үндсэн цалин	641,615,700.00	628,609,737.31
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	58,478,400.00	55,135,947.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,777,000.00	46,266,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,885,600.00	102,884,800.00
210201	Тэтгэврийн даатгал	72,581,100.00	72,581,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,278,400.00	7,278,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,822,700.00	5,821,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,455,700.00	1,455,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,747,700.00	15,747,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,343,200.00	29,180,047.52
210301	Гэрэл, цахилгаан	4,896,000.00	4,732,847.52
210302	Түлш, халаалт	23,580,000.00	23,580,000.00
210303	Цэвэр, бохир ус	867,200.00	867,200.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	7,064,200.00	7,057,809.00
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,240,799.00
210402	Тээвэр, шатахуун	4,139,400.00	4,137,860.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	-	-
210404	Ном, хэвлэл	200,000.00	197,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,504,800.00	1,362,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	23,327,800.00	23,187,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,635,000.00	1,635,000.00
210502	Хоол, хүнс	19,692,800.00	19,552,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,686,500.00	3,683,700.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	-
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	560,000.00	560,000.00
210604	Урсгал засвар	3,126,500.00	3,123,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,486,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,486,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	726,600.00	724,981.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	726,600.00	724,981.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,379,700.00	1,379,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,379,700.00	1,379,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,665,400.00	17,665,359.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,665,400.00	17,665,359.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,565,100.00	12,565,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,100,300.00	5,100,259.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлан он
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,670,411.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,670,411.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,670,411.00
2104	Хангамж, бараа материалын зардал	936,811.00
210401	Бичиг хэрэг	75,151.00
210402	Тээвэр, шатахуун	439,760.00
210404	Ном, хэвлэл	280,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	141,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,050,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,653,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,653,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,030,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,030,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,708,711.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,708,711.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	4,516,811.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,191,900.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадал суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 17 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 965.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 15.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,9 хувиар буюу 114.1 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 89.9 сая төгрөг болж 30.5 сая төгрөгөөр буурсан нь түлш шатах тослох материалын эхний үлдэгдлийг зарцуулсантай, мөн бараа материал акталж, данснаас хассантай холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 73.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 5.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 93.4 сая төгрөгийн материалыг зарцуулж, 15.8 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,454.8 сая төгрөг болж 26.3 сая төгрөгөөр буурсан нь ОНӨХГазрын шийдвэрээр үндсэн хөрөнгө акталж устгасантай холбоотой. Тайлант хугацаанд 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 9.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн 28.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,188.5 сая төгрөг болж 114.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 97.4 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй авсан бараа материал үндсэн хөрөнгө буурсантай холбоотой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,464.9 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,270.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 335.6 сая төгрөгөөр бууруулж, 934.4 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 934.4 сая төгрөгийн төсөв баталснаас 901.9 сая төгрөгийг улсын төсвөөс 32.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 934.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 32.5 сая төгрөг, нийт 901.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 917.2 сая төгрөгийг зарцуулж 17.0 сая төгрөгийг улсын төсөвт, 0.2 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 917.2 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 16.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.1 сая төгрөгөөр, нормативд зардлыг 0.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 5.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 1.0 сая төгрөгийг хангамж бараа материалын зардалд, 1.0 сая төгрөгийг багаж техник хэрэгслийн зардалд, 1.6 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 2.1 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 132 мэдээллээс 119 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 13 мэдээллийг хугацаа хоцроосон. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 872.8 сая төгрөгийн 12 орлогын гүйлгээ мэдээлээгүй байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн зарим холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд и баримтгүй 11.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 13.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Үндсэн хөрөнгийн тооллого
- Цалин нэмэгдэл хөлс
- Шатахууны зарцуулалт тооцоо бодолт
- Шилэн дансны мэдээлэл
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.8 сая төгрөгийн алдааг залруулж, 9.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад ОНӨГ-ын тогтоол шийдвэргүй үндсэн хөрөнгийг данснаас хассан 7.3 сая төгрөг, бараа материал худалдан авсныг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгэсэн 0.8 сая төгрөг, үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн 0.8 сая төгрөг, шилэн дансанд дутуу мэдээлсэн 12 мэдээллийг нөхөн мэдээлж, үнэ төлбөргүй хүлээн авсан 2.9 сая төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгэн, залруулав.

4.2 Төлбөрийн акт

- Багш нарын амралтыг буруу тооцон 0.2 сая төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажилтанд 2.2 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно", заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэхээр акт тогтоолоо.
- 7.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг төсөв захирагчийн тушаал шийдвэртэй байхад олгоогүй. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "төрийн албан хаагчид мөнгөн урамшил олгох журам"-ын 4.1 дэх заалт "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (цаашид сургалтын байгууллага гэх)-ын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно", 4.3 дахь заалт "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын дотоод журам албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", Алтай сумын сургуулийн захирлын 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/12 тоот тушаалыг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.
- Томилолтын тооцоо бодоогүй, илтгэх хуудасгүй 0.1 сая төгрөгийн томилолт олгосон нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдэгдлийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

- Орон нутгийн өмчийн газар нь тус сургуулиас ирүүлсэн актлах хөрөнгийн жагсаалтын мөнгөн дүнг давтан шалгаж, хөрөнгийн бүртгэлтэй тулгаагүйн улмаас

2020 онд акталж дахин үнэлсэн 1.2 сая төгрөгийн хөрөнгийг 2021 онд дахин акталж, данснаас хасах аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.2.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Жолоочийн замын хуудаст спидометрийн заалт, машины марк, явсан километр бичээгүй, тооцоо бодолгүйгээр 3.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан.Энэ нь санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдэгдлийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд 0.4 сая төгрөгийг тээвэр шатахууны зардлаас гаргаж гэрэл цахилгаан зардал буюу мотор асаахад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд и баримтгүй 11.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Татварын ерөнхий хуулийн 28.2-т “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ.” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд 7.1 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ,14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1,тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 872.8 сая төгрөгийн орлогын гүйлгээг байршуулаагүй.
- 1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангаагүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг мөрдөж ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль	17	45.5	5	11.8	4	9.7	7	24.0	1	-
	Дүн	17	45.5	5	11.8	4	9.7	7	24.0	1	-

/сая төгрөгөөр/